

Э-Сонин

34 дахь дугаар



ГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

WWW.MSE.MN

2015 он 8 сар

Мэдээний Тойм



НАЙМДУГААР САРЫН ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

ТҮҮХЭН ДЭХ ХАМГИЙН ДЭЭД АРИЛЖААГАА ХИЙЛЭЭ



"ЭРЧИМ БОНД"-ЫН АРИЛЖАА АМЖИЛТТАЙ ЯВАГДАЖ, ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГ НЭЭЛЭЭ

"БИНСЭ" ХК-ИЙН ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГ НЭЭЛЭЭ



УУЛ УУРХАЙН КОМПАНИУДЫГ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРГАНА

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС ГАРГАСАН ШИЙДВЭРҮҮД



Д.АНГАР: ИЙМ ӨНДӨР ХҮҮТЭЙ БОНД АРИЛЖИХ КОМПАНИ ЦААШИД ГАРАХГҮЙ

ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИУДЫН СУЛ ЧӨЛӨӨТЭЙ МӨНГӨН ХӨРӨНГИЙНГ ҮР АШИГТАЙ УДИРДАХ БОЛОМЖ БАЙНА



ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ

- Монголын хөрөнгийн бирж 5041 дэх арилжаагаар түүхэн дэх дээд амжилтаа шинэчлэн тогтоов.
- “Эрчим инженеринг” ХХК-ийн гаргасан бондыг амжилттай болсонд тооцож, хоёрдогч зах зээлийн арилжааг нээв.
- “Бинсэ” ХК-ийн анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцож хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэв.
- Монголын геологи, уул уурхайн мэргэжлийн институт монголын хөрөнгийн биржтэй хамтран сургалт зохион байгууллаа.
- Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрээр Түшиг траст ХХК-ийн харилцагчдыг шилжүүлэн авах сонгон шалгаруулалтыг эхлүүлэв.
- Д.Ангар: Ийм өндөр хүүтэй бонд арилжих компани цаашид гарахгүй гэж үзэж байна.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

- 8 дугаар сарын арилжааны мэдээ

СУРГАЛТ

“Үнэт цаасны зах зээлийн анхан шатны суурь мэдлэг олгох” сургалт”-ыг 2015 оны 9 дүгээр сарын 21-ны өдөр явуулахаар төлөвлөж байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг 11313747 -126 дугаараас авна уу.



НАЙМДУГААР САРЫН ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь 2015 оны 7 сарын эцсийн байдлаар үндсэн үйл ажиллагаанаас нийт 872,770,265.79 төгрөгийн орлого олж, үйл ажиллагааны зардал 665,680,210.66 төгрөг гаргасан. Үүнээс цалин, түүнтэй холбогдох зардалд нийт 358,979,443.96 төгрөг, ашиглалтын болон бусад зардалд 306,700,766.70 төгрөг зарцуулсан байна. Нийт ашиг өссөн дүнгээр 207,090,055.13 төгрөг байна.

Мөн 5,000,000.00 төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт хийгдээгүй болно.

ТҮҮХЭН ДЭХ ХАМГИЙН ДЭЭД АРИЛЖААГАА ХИЙЛЭЭ

Монголын хөрөнгийн бирж 1991 онд байгуулагдаж, 1995 оноос бэлэн мөнгөний арилжаа буюу үнэт цаасны хоёрдогч зах зээл эхэлснээс хойш 5050 удаагийн арилжааг зохион байгуулж байна.

2015 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 5041 дэх ээлжит арилжаагаар 10 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж 2015 он гарсаар хийгдсэн нийт арилжааны дүн 354.4 тэрбум төгрөгт хүрсэн нь Монголын Хөрөнгийн биржийн 25 жилийн түүхэн дэх хамгийн дээд арилжаа боллоо.



"ЭРЧИМ БОНД"-ЫН АРИЛЖАА АМЖИЛТТАЙ ЯВАГДАЖ, ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГ НЭЭЛЭЭ



Монголын анхны даатгагдсан компанийн бонд болох "Эрчим бонд"-ын анхдагч зах зээлийн арилжааны захиалга эхэлсэнтэй холбогдуулан МХБ-ийн Гүйцэтгэх захирал Д.Ангар, "Эрчим инженеринг" ХХК-ийн Ерөнхий захирал М.Батболд, Голомт банкны Хөрөнгө оруулалтын банкны газрын захирал Ж.Хишигжаргал нар "Цан" цохин Монголын хөрөнгийн биржийн 5037 дахь удаагийн арилжааг нээлээ.

"Эрчим бонд" нь 10,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 18.5 хувийн хүүтэй, 6 сарын хугацаатай бөгөөд захиалгыг 2015.08.12-2015.08.20 өдрүүдэд хүлээн авч 2015.08.21 өдөр анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдаж, бондын хоёрдогч зах зээлийн арилжааг 2015 оны 08 дугаар сарын 25-ны өдөр эхлүүлсэн.

Уг үнэт цаасыг худалдан авахыг сонирхсон хөрөнгө оруулагчид захиалгыг Монголын хөрөнгийн биржийн гишүүн үнэт цаасны компаниудаар дамжуулан өгч болно.



“БИНСЭ” ХК-ИЙН ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГ НЭЭЛЭЭ

БИНСЭ

"Бинсэ" ХК-ийн нэмж гаргаж буй хувьцаа нэг бүрийг нь 744 төгрөгөөр олон нийтэд санал болгож байгаа юм. Тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг 2015 оны 6 дугаар сарын 3-ны өдрөөс 07 дугаар сарын сарын 28-ны өдөр хүртлэх хугацаанд зохион байгуулсан юм. Тус арилжаагаар нийт 800,000 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгосноос 150,814 ширхэг хувьцааг арилжсан байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1/3703 албан тоотоор тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцож, хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэхийг мэдэгдсэн байна. Монголын хөрөнгийн бирж тус арилжааг 2015 оны 08 дугаар сарын 17-ны өдрөөс эхлүүллээ.



УУЛ УУРХАЙН КОМПАНИУДЫГ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРГАНА

Монголын хөрөнгийн бирж, Монголын геологи, уул уурхайн мэргэжлийн институттэй харилцан ойлголцож, хамтран ажиллах тухай санамж бичгийг байгуулсан.

Хамтын ажиллагааны хүрээнд Уул уурхай ашигт малтмалын ордын нөөцийг нээлттэй тайлагнах /MRC Code/-ын журмын танилцуулга сургалт, семинарыг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, Үнэт цаасны компаниудад 2015 оны 8 дугаар сарын эхний хагаст зохион байгуулсан.

8 дугаар сарын 17-ны өдөр Монголын хөрөнгийн биржээс геологи, уул уурхайн компаниудад Хөрөнгийн зах зээлээс хэрхэн яаж хөрөнгө босгож болох, гадаад бүртгэлтэй компаниуд Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэхийн давуу тал зэрэг сэдвээр сургалт, семинар явууллаа. Тус сургалтад :

“Эрдэнэс таван толгой” ХК

“Энержи Ресурс” ХХК

“Майн инфо” ХХК

“Уянгео Ресурс” ХХК

“Мегатон Минералс” ХХК

“Интернэшнл Майнинг консалтинг” ХХК

“Сапфир Гео” ХХК

“IMC” ХХК

“Их Баялаг Майнинг” ХХК зэрэг компаниудын төлөөлөл оролцов.

Сургалтын үеэр Стратегийн орд газрын 10 хувийг Монголын хөрөнгийн биржээр арилжаалах тухай Ашигт малтмалын тухай хуулийн 5.6 заалтыг хангах хүрээнд “Эрдэнэс таван толгой” ХК, “Энержи Ресурс” ХХК-иудад зөвлөгөө, мэдээлэл өгснөөс гадна уул уурхайн хайгуулын лицензтэй жижиг компаниудад зориулсан хөрөнгийн биржийн 3-р ангиллын боломжийн талаар нээлттэй хэлэлцүүлэг хийв.





УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТ ЯВУУЛАХ ТУХАЙ

Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон “Глобал-Ассет” ХХК-ийн харилцагчдыг уралдаант шалгаруулалтын үндсэн дээр бусад тусгай зөвшөөрөлтэй компаниудад шилжүүлэх ажлын хэсгийг Хорооны даргын 2015 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 214 дүгээр тушаалаар байгуулав.

Иймд үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон “Глобал-Ассет” ХХК-ийн харилцагчдыг шилжүүлэн авах сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн компани Хорооны 2008 оны 221 дүгээр тогтоолоор баталсан “Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон брокер, дилерийн компанийн харилцагчдыг шилжүүлэх тухай журам”-ын 3.2-т заасан бичиг баримтыг бүрдүүлж, битүүмжлэн 2015 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн дотор тус Хорооноос байгуулсан ажлын хэсэгт ирүүлнэ үү.

№	Үнэт цаасны компанийн нэр	Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны төрөл	Харилцагдын тоо	Харилцагч банк
1	“Глобал-Ассет” ХХК	Брокер, дилер, хөрөнгө оруулах зөвлөл	358	Голомтбанк, Хасбанк

Ажлын хэсэг уралдаант шалгаруулалтад ирүүлсэн бичиг баримтыг хүлээн авах сүүлийн хугацаанаас хойш ажлын 15 хоногийн дотор шийдвэрлэж, холбогдох харилцагчдыг шилжүүлэх болно.

Эх сурвалж: САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Д.АНГАР: ИЙМ ӨНДӨР ХҮҮТЭЙ БОНД АРИЛЖИХ КОМПАНИ ЦААШИД ГАРАХГҮЙ

-Компанийн даатгагдсан бондын эрэлт хэр байна вэ?

- “Эрчим” бондын нийт үнийн дүн 500 сая төгрөг байгаа. Уг бондыг биржид бүртгэснээс хойш ердөө нэг цагийн дотор дээрх дүнгээс давсан захиалга ирсэн. Тэгэхээр нийлүүлэлтээс хэд дахин давсан захиалга ирнэ гэж бодож байна. Учир нь уг бонд арилжааны банкуудын хадгаламжаас өгөөж өндөртэй, бас найдвартай. Мөн хоёрдогч зах зээлд бондоо зараад хүссэн үедээ мөнгөө авч болно. Тиймээс эрэлт их байх нь тодорхой юм. Гэхдээ “Эрчим” бондыг хувь нийлүүлэх хэлбэрээр буюу тэгш хуваарилах учраас эрэлт их байсан ч захиалга өгсөн хүн бүр авах боломжтой.

-“Эрчим” бондын арилжаа амжилттай болж буй гэж ойлгож байна. Үүнээс гадна бонд гаргах сонирхолтой компани бий юу?

-Хөрөнгийн зах зээлийн оролцогчид энэ ажлыг нааштайгаар хүлээн авлаа. Өмнө нь аж ахуйн нэгжүүдэд мөнгө босгох ганц л зам байсан. Харин одоо бонд гаргаад санхүүжилт татах боломж бүрдэж, бас нэг зам нээгдлээ. Энэ үнэт цаас санхүүгийн найдвартай хэрэгсэл гэдэг нь олон улсад батлагдсан учир бонд гаргах ажил манайд ч амжилттай болно гэж бодож байгаа. Одоогийн байдлаар гурван компани 5-10 тэрбум төгрөгийн бонд гаргахаар судалж буй. Бид Монголын ТОП 100 компанийг үе шаттайгаар хөрөнгийн зах зээл рүү оруулж, бондоо гаргахад нь тусалж дэмжинэ. Ингээд цаашид компаниуд хувьцаагаа олон нийтэд нээлттэй арилжих боломжтой.

-Бондоо гаргах компанид ямар шалгуур тавих вэ?



-Компанийн бонд бол хөрөнгийн зах зээлийн зээл гэсэн үг. Тиймээс гол шалгуур нь зээлээ найдвартай төлөх чадвартай л байх ёстой. Мөн тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг судалж байж даатгал хийх учраас шалгуур нь өндөр байна. Ингээд бонд гаргасан компани зээлээ эргүүлэн төлж чадахгүй бол даатгагч хариуцна. Иймд даатгалын компаниудад тавих шаардлага ч нэмэгдэнэ. Сүүлийн 25 жилийн хугацаанд банкны салбар өндөр хөгжсөн. Гэтэл хөрөнгийн зах зээл болон даатгалын салбарын хөгжил сул байлаа. Аль аль нь томоохон хэмжээний гүйлгээнд бэлэн биш байна. Тиймээс энэ жил хамгийн ихдээ 10-20 тэрбум төгрөгийн даатгагдсан бондын арилжаа хийх боломжтой. Ямартай ч энэ хоёр салбар зэрэг хөгжих

боломжтой боллоо.

-Энэ бондыг иргэд хэр захиалж байна вэ?

-Захиалгын сан хаагаагүй байгаа учир одоогоор дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломжгүй. 10 мянга эсвэл 500 сая төгрөгийн ч захиалга өгч болно. Гэхдээ манай иргэдийн санхүүгийн боловсрол бага байна. Арилжааны банкин дахь иргэдийн харилцах дансанд 100-200 мянган төгрөг байж л байдаг. Тиймээс 50-100 мянган төгрөгөөр компанийн бонд авч, хөрөнгийн зах зээлд тоглоод сурчихвал ядаж хөрөнгө нь өснө шүү дээ. Монголын хөрөнгийн бирж иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтын соёлтой болгоход анхаарч ажиллана.

-Засгийн газрын үнэт цаасыг (ЗГҮЦ) Хөрөнгийн биржээр дамжуулан арилждаг болсноор хүү нь буурч байх шиг байна.

-ЗГҮЦ-ыг өмнө нь зөвхөн Монгол банкаар дамжуулан арилждаг байх үед хүү нь есөн хувиас 16 хүртэл өссөн. Харин одоо 1.5-2 хувиар буурлаа. Ингэснээр компаниудын бондын хүү дагаад буурах боломжтой. Цаашид 18 хувийн хүүтэй бонд гаргах компани олдохгүй болов уу. Тиймээс хөрөнгө оруулагчид энэ боломжийг ашиглах хэрэгтэй. Бид компанийн бондын хүү 12-15 хувь болж буурна гэж таамаглаж байгаа.

-Ойрын үед өөр шинэ бүтээгдэхүүн гаргах төлөвлөгөө бий юу?

-Зах зээл бүрэн хөгжөөгүй учраас шинэ бүтээгдэхүүн гаргахад хүндрэлтэй байна. ЗГҮЦ-ыг Монголын хөрөнгийн биржээр арилжаад 8-9 сар өнгөрлөө. Компанийн бондын арилжааг одоо л хийх гэж байна. Тэгэхээр цаашид шинэ бүтээгдэхүүн гаргах боломж гарна.

Тухайлбал компанийн бондод суурилсан үүсмэл санхүүгийн хэрэгсэл байж болно.

-Төрийн өмчийн зарим компанийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан хувьчлахаар болсон. Энэ ажлын бэлтгэл хэр байна вэ?

-Төрийн өмчийн есөн компанийн тодорхой хэсгийг биржээр дамжуулан хувьчлах тогтоолыг УИХ-аас гаргасан. Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржээс дээрх компанийн удирдлагууд болон Төрийн өмчийн хорооны ажилтнуудад энэ чиглэлээр сургалт хийлээ. Энэ онд 2-3 компанийг хувьчлах байх. Хөрөнгийн бирж бэлтгэлээ хангасан. Одоо хөрөнгө оруулагчдаа олох, сурталчлах зэрэг компаниудын болон Төрийн өмчийн хорооны ажил үлдсэн. Энэ компаниудыг нээлттэй, олон нийтийн компани болгоё гэвэл хувьчлалыг ил тод, хялбар аргаар хийх ёстой. Мөн хувьцааг нь аль болох олон хүнд тараах хэрэгтэй.

Эх суравалж: Өдрийн сонин 2015.08.18
Н.Санжаасүрэн

ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИУДЫН СУЛ ЧӨЛӨӨТЭЙ МӨНГӨН ХӨРӨНГИЙНГ ҮР АШИГТАЙ УДИРДАХ БОЛОМЖ БАЙНА

Төрийн өмчит компаниудын харилцах дансан дахь сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг үр ашигтай удирдах боломжийн талаар Хөрөнгийн биржээс ТӨХ-д санал хүргүүлсэн бөгөөд ТӨХ-ны зүгээс төрийн өмчит компаниуд уг үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийж, сул чөлөөтэй мөнгө хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн тухай мэдэгдсэн юм.

Уг ажлын хүрээнд 2015 оны 8 дугаар сарын 19-ний өдөр МХБ-ээс "Дулааны цахилгаан станц-4" ТӨХК-д Засгийн газрын үнэт цаас худалдан авах замаар богино хугацааны хөрөнгө оруулалт хийж, үндсэн үйл ажиллагаанаас гадуур хүүгийн нэмэлт орлого олох боломжийн талаар дэлгэрэнгүй танилцуулга хийлээ. Тус компанийн зүгээс талархалтайгаар хүлээн авч, уг үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийж сул чөлөөтэй мөнгө хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх талаар судалж үзэх тухайгаа илэрхийллээ.



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЛЭГ ОЛГОХ ЭЭЛЖИТ СУРГАЛТ ӨНДӨРЛӨЛӨӨ



ТӨГСӨЛТИЙН БАЯР



Монголын Хөрөнгийн Биржийн “Үнэт цаасны зах зээлийн мэдлэг олгох” анхан шатны ээлжит сургалт 2015 оны 8 дугаар сарын 10-наас 8 дугаар сарын 14-ний хооронд явагдаж дууслаа.

Сургалтыг онол-практикийг хослуулан Брокер, дилерийн компанийн үйл ажиллагаатай танилцуулах, арилжаанд оролцуулах хэлбэрээр явуулсан нь суралцагчдын сонирхолд ихэд нийцсэн сургалт боллоо.

Сургалтад цаашид хамрагдах сонирхолтой иргэд, оюутан залуусын тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа нь нийгмийн эрэлт хэрэгцээ их байгаагийн илрэл юм. Иймд бид дараагийн сургалтыг 2015 оны 9 дугаар сарын 21-ний өдрөөс явуулахаар төлөвлөж байна.

Үнэт цаасны зах зээлийн боловсролоо дээшлүүлэх үйлсэд Тань амжилт хүсье



2015 оны 8 дугаар сар


Арилжааны товч мэдээ

Арилжигдсан ширхэг	744,389
Нийт үнийн дүн /төг/	37,196,968,352
Хэлцлийн тоо	659
Арилжигдсан үнэт цаасны тоо	58
Зах зээлийн үнэлгээ /төг/	1,262,994,806,097

ТОП-20 индекс

Хаалт	12,890.12
Өмнөх сарын хаалт	13,811.64
Өөрчлөлт /нэгж/	-921.52

TOP 20 INDEX



Идэвхтэй арилжигдсан үнэт цаас:

Тоо ширхэгээр:					Үнийн дүнгээр:				
№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн	№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн
1	MRX	МЕРЕКС	103,451	8,177,955	1	BLC	БҮТЭЭЛЧ ҮЙЛС	37,579	33,821,100
2	HGN	ХӨХ ГАН	79,659	6,274,258	2	BDL	МОГОЙН ГОЛ	3,528	27,070,960
3	BLC	БҮТЭЭЛЧ ҮЙЛС	37,579	33,821,100	3	TTL	ТАВАН ТОЛГОЙ	3,463	11,474,390
4	OLL	ОЛЛОО	33,935	3,360,355	4	GOV	ГОВЬ	1,277	11,325,340
5	RMC	РЕМИКОН	6,366	422,565	5	MRX	МЕРЕКС	103,451	8,177,955

Хамгийн их өсөлттэй үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					хувь
1	NKT	ТАХЬ-КО	15,850.00		44.22
2	DHU	РЕМИКОН	69.00		26.86
3	AOI	МОГОЙН ГОЛ	7,700.00		18.92
4	NEH	МОНГОЛЫН ХӨГЖИЛ	4,250.00		14.86
5	MBG	БӨӨНИЙ ХУДАЛДАА	560.00		14.29

Хамгийн их бууралттай үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					хувь
1	SOR	УБ-БУК	30,000.00		-6.60
2	MMX	МАХИМПЕКС	3,013.00		-8.20
3	SOR	СОР	1,480.00		-8.53
4	EER	АРИГ ГАЛ	2,350.00		-11.36
5	SHV	ШИВЭЭ ОВОО	4,950.00		-14.29

Засгийн газрын үнэт цаас: /анхдагч зах зээл/

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнэ	Үнийн дүн	Хугацаа /долоо хоног/	Хүүгийн хэмжээ %
1	ЗГХБ-Б-52-322	100,000	8,727,900,000.00	87,279	52	14.615
2	ЗГХБ-Б-12-323	100,000	9,685,300,000.00	96,853	12	14.118
3	ЗГХБ-Б-25-324	100,000	9,298,300,000.00	92,983	28	14.054
4	ЗГХБ-Б-52-325	100,000	8,725,300,000.00	87,253	52	14.65

Засгийн газрын үнэт цаас: /хоёрдогч зах зээл/

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Дээд ханш	Доод ханш	Сүүлийн ханш
1	ZGEB-BL-09/02/16-A0045-0	10	954,200.00	95420.00	95420.00	95420.00
2	ZGEB-BL-13/10/15-A0044-0	11	1,083,280.00	98480.00	98480.00	98480.00
3	ZGEB-BL-22/09/15-A0041-0	10	990,000.00	99000.00	99000.00	99000.00
4	ZGEB-BL-27/10/15-A0025-0	11	1,078,000.00	98000.00	98000.00	98000.00
5	ZGEB-BD-26/05/16-A0035-15,75	1,000	100,900,000.00	100900.00	100900.00	100900.00